



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 641

Улаанбаатар хот

“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчийт хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийт компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны А/77 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 05/19649 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчийт хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд Хараат бус гишүүнээр Л.Амгалан, Б.Үүрцайх, Ж.Галбадрах нарыг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг хараат бус гишүүн Л.Амгалан, Б.Үүрцайх, Ж.Галбадрах нарт, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудад тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ